

Монгол Улс Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ

2024 ОНЫ НЭМЭЛТ ТОДРУУЛГА: ХУРААНГУЙ



Хураангуй тойм

Монгол Улсын 2024 оны хөгжил, ахиц дэвшлүүд нь 2023-2027 онд хэрэгжүүлэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБ-ын ТХХАХ)-ний хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж буйд үнэлгээ дүгнэлт хийхээр Монгол Улсын Хөгжлийн төлөв байдлын шинжилгээний (ХТБШ) 2024 оны шинэчилсэн хувилбарыг боловсрууллаа. НҮБ-ын ТХХАХ баримт бичгийг боловсруулах зорилгоор 2021 онд хийсэн Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээний үндсэн агуулга хүчинтэй хэвээр байх бөгөөд 2024 оны шинэлэг мэдээллээр уг шинжилгээг нэмж баяжуулсан болно.

Нийгэм-эдийн засгийн шинжилгээ

Монгол Улс 2023 оноос эхлэлтэй эдийн засгийн өсөлтийн эрчээ үргэлжлүүлж, 2024 оны туршид илүү өөдрөг ажиллалаа. Гэвч Монгол Улсын эдийн засаг 4.9 хувьд хүрч өсөхөд олборлох салбарын экспорт давамгайлсан (93 хувь) хэвээр бөгөөд дийлэнх нь зөвхөн нэг л зах зээлд нийлүүлэлт хийсэн (91.4%) байна. Ийнхүү экспортод түшиглэсэн эдийн засгийн өсөлт нь тэнцвэр муу, гадаад нөлөөнд хэт өртөмтгий байх тул Монгол Улсын эдийн засгийг нэн яаралтай төрөлжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд цахим гэмт хэргийн тохиолдол эрс нэмэгдсэн. 2020 онд цахим гэмт хэргийн 1795 тохиолдол бүртгэгдсэн бол 2023 онд 9270, 2024 оны эхний найман сарын байдлаар 6236 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Интернет болон харилцаа холбооны хөдөлгөөнт сүлжээнд иргэд улам олноор нэвтрэх болсны хэрээр хэрэглэгчид цахим орчинд аюул заналхийлэлд өртөх эрсдэл нэмэгдэж, нийгмээрээ цахим платформуудад итгэх итгэлд сөргөөр нөлөөлөх болсныг энэхүү хандлага илэрхийлж байна. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил нэмэгдэж байна. 2023 оны эхний 9 сард ийм гэмт хэргийн 292 тохиолдол бүртгэгдсэн бол 2024 оны мөн үед 301 тохиолдол болж нэмэгдсэн байна. Шалгагдаж буй авлигын хэргийн тоо 2024 оны эхний хагас жилд 860 болсон нь өмнөх оны мөн үеэс бараг 15 хувиар өссөн байна.

Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) 2022 онд 0.741 болж дэлхийн 193 орноос 96-д эрэмбэлэгдэж, хүний хөгжлийн түвшин өндөртэй орнуудын ангилалд багтжээ. Тус улс 2024 онд Дундаас дээш орлоготой улс (ДДОУ/UMIC)-ын статустай болсон. Гэсэн хэдий ч нүүрсхүчлийн хийн ялгаруулалт болон материаллаг ул мөр буюу байгаль эх

дэлхийд учруулж буй дарамтыг тооцсон хүний хөгжлийн индекс (ДУД ХХИ/PHDI)-ээс харахад Монгол Улсын өнөөгийн хөгжлийн загвар нь байгаль орчинд тодорхой нөлөө үзүүлж буйг харуулж байна. Монгол Улс нь нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий ялгаруулалтаар тэргүүлж буй орнуудын тоонд орж байна. 2022 онд Монгол Улсын эх дэлхийд учруулж буй дарамтыг тооцсон хүний хөгжлийн индекс нь тус улсын ХХИ-ийн ерөнхий түвшинг 16.5 хувиар бууруулж байв. Энэ нь Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд хамгийн өндөр нөлөөтэй хүчин зүйл болж байгаагийн зэрэгцээ тус улсын өсөлтийн замнал тогтворгүй байгааг харуулж байна.

Монгол Улсын хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 2024 оны 4-р улиралд дунджаар 62.2 хувь, үүнээс эрэгтэйчүүдийнх 71.4 хувь, эмэгтэйчүүдийнх 53.7 хувь буюу харьцангуй бага хэвээр байна. Нийт хөдөлмөр эрхэлж буй хүн амын 46 орчим хувь нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Ажиллах хүчний багагүй хэсэг хөдөлмөрийн хуулиар зохицуулагдаагүй, хамгаалагдаагүй ажил хөдөлмөр эрхэлж байгаа нь тогтворгүй байдалд хүрэх, нийгмийн хамгаалал, тэтгэмж авч чадахгүй болох зэрэг эрсдэл дагуулж болзошгүй. Албан бус хөдөлмөр эрхэлж буй хүмүүс голчлон хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, барилга, тээвэр, ложистик зэрэг салбарт ажиллаж байна. Шаардлагатай ур чадварт нийцэхгүй байх, хөдөлмөрийн бүтээмж муу зэрэг нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд томоохон сорилт болж, улмаар ажилчид тогтвор суурьшилгүй байх, цалин хөлс бага байх нөхцөлд хүргэж байна.

Монгол Улсын эрчим хүчний систем нь тус орны байгалийн арвин нөөц болох чулуун нүүрсний үйлдвэрлэлд түшиглэж байна. Үүний улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг үр дагавар нь тус улсыг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд улам өртөмтгий болгож байна. Айл өрхүүд өвлийн улиралд шахмал түлш, бусад шатаах материалыг гэрийнхээ халаалтад ашиглаж байгаа нь агаарын бохирдол үүсэхэд ихээхэн нөлөөлдөг. Засгийн газраас 2024 оны арваннэгдүгээр сард цахилгаан эрчим хүч, дулааны үнэ тарифыг нэмэгдүүлсэн. Хэдийгээр энэ нь эрчим хүчний үйлдвэрлэлийн өртгийг нөхөхөд нэн шаардлагатай арга хэмжээ боловч инфляцид нөлөөлж, ялангуяа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур болон ойролцоо орлогоор амьдарч буй хүмүүсийн аж амьдралд хүндээр туссан.

Сэргээгдэх эрчим хүчний шилжилт нь Монгол Улсын ногоон болон төрөлжсөн эдийн засгийн загварыг эргэн харах боломж гэж үзэж байна. Монгол Улс цэвэр бөгөөд хямд эрчим хүч рүү шилжсэнээр байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллөө бууруулж, нийгмийн эрүүл мэндийг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийн шинэ боломжийг нээж чадна.

Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлт, хүнсний импортоос ихээхэн хамааралтай тул эрүүл, зохистой хүнсний хүртээмжийг хямд үнээр хангахад бэрхшээлтэй тулгарч байна. Хямд бөгөөд хэт боловсруулсан бэлэн хоол хүнс олдоц ихтэй, мөн өдөр тутмын хэрэгцээнд шаардлагатай жимс, хүнсний ногоо хангалтгүй байгаа нь илүүдэл жинтэй хүмүүсийн тоо нэмэгдэхэд нөлөөлж байна. Өнөөгийн байдлаар Монгол Улсын 15-69 насны нийт хүн амын 31 хувь, хүүхдүүдийн 73 хувь нь илүүдэл жинтэй, таргалалттай байна. Үүний зэрэгцээ Монгол Улсад хүнсний аюулгүй байдал нь анхаарвал зохих ноцтой асуудлын нэг болсон юм. Нийт өрхийн 4.78 хувь нь хүнсний аюулгүй байдал нь дунд болон хүнд нөхцөлд алдагдсан гэх судалгааны тооцоолол байна. Монгол Улс дотооддоо цөөн нэрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг учир хүнсний импортоос ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, тахиа, шувууны махны 98 хувь, ургамлын тосны 98.5 хувь, буурцаг, будаа, элсэн чихрийг 100 хувь импортоор авч байна.

Монгол Улс цахим шилжилтийн чиглэлд ахиц дэвшил гаргаж байгааг НҮБ-ын системийн байгууллагуудын нийтэлсэн олон улсын үзүүлэлтүүд илэрхийлж байна. Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ/ITU)-ын нийтэлсэн 2024 оны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн индекс (МХХТИ/IDI)-ээр Монгол Улс 87 оноо авч, 2023 онтой харьцуулахад нэг хувиар нэмэгджээ. Цахим засаглалын хөгжлийн индекс (ЦЗХИ/EGDI)-ээр 2022 онд дэлхийн 193 орноос 74-т жагсаж байсан Монгол Улс 2024 онд 46-д эрэмбэлэгдэж, үсрэнгүй урагшилсан байна. Гэвч тус улсын Хүний капиталын индекс 2022 онтой харьцуулахад 2024 онд мэдэгдэхүйц буурсан байгааг тэмдэглэх хэрэгтэй. Монгол Улсын Засгийн газар e-Mongolia 4.0 хувилбарыг нэвтрүүлж төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр ард иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлаа үргэлжлүүлж байна. Мөн төрийн цахим үйлчилгээний төрөл, хүртээмжийг илүү сайжруулах зорилгоор 2023 онд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг байгуулсан.

Монгол Улс нь 2021-2030 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө зэрэг санаачилгад тулгуурлан боловсролын салбарын бүх шат, төрөл хэлбэрийг хамарсан томоохон шинэчлэл хэрэгжүүлж байна. Монгол Улс 2023 онд Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулж, сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байхаар (6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг) зааж, 2024 оны долдугаар сараас эхлэн англи хэлний хичээлийг ерөнхий боловсролын

3-р ангиас эхлэн заахаар Засгийн газар шийдвэрлэсэн. Сүүлийн жилүүдэд улсын төсвөөс боловсролын салбарт хуваарилах төсвийн зардал ихээхэн нэмэгдсэн. Монгол Улсын боловсролын системд суралцагчдын элсэлт, төгсөлтийн түвшин өндөр хэвээр байгаа хэдий ч сайжруулах шаардлагатай зүйлс байна. Боловсролын байгууллагад хүүхдүүд дунджаар 13.2 жил суралцаж байгаа хэдий ч чанартай 8.8 жилийн боловсролтой тэнцэхүйц хэмжээний боловсрол эзэмшиж байна. Хамгийн бага орлоготой бүлэгт хамрагдах айл өрхийн хүүхдүүд унших, тоо бодох, шинжлэх ухааны чиглэлээр хамгийн өндөр орлоготой бүлэгт хамрагдаж буй айл өрхийн үе тэнгийнхнээсээ ойролцоогоор 4.5 жилээр хоцрогдолтой байна.

Байгаль орчны шинжилгээ

2024 оны Байгаль орчны гүйцэтгэлийн индекс (БОГИ/ЕРI)-ийн тайланд Монгол Улс 37.2 оноо авч 143 дугаарт жагсчээ. Агаарын чанар (160-р байр), хог хаягдлын менежмент (176-р байр), хөдөө аж ахуй (174-р байр), уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах (177-р байр) зэрэг томоохон сорилтуудтай тулгарч байгаа бол биологийн олон янз байдал, амьдрах орчны хувьд харьцангуй өндөр оноо (34-р байр) авсан байна. Дэлхийн банкны тайланд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх болон хөгжлийн зорилтуудаа хэрэгжүүлэхийн тулд ирэх 25 жилийн хугацаанд 10 гаруй тэрбум ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай хэмээн тэмдэглэжээ.

Монголд 2023/2024 оны өвөл зуд нүүрлэж, бэлчээрийн мал аж ахуйд түшиглэн амьжиргаагаа залгуулдаг малчдад хүндээр туссан. 2023/2024 онд тохиосон зудын нийгэм, эдийн засгийн нөлөөллөөс дурдвал, 8.1 сая толгой мал хорогдож, хөдөө аж ахуйн салбарын ДНБ 27 хувиар буурсан төдийгүй гамшигт нэрвэгдсэн малчин өрхийн нэг гишүүнд ногдох цэвэр орлого 12-20 хувиар (зарим өрхөд түүнээс ч илүү) буурч, малын ашиг шим цагаан идээний боловсруулалт, өрхийн үйлдвэрлэл хумигдаж, нийт малчин өрхийн 20 орчим хувьд эрүүл мэндийн асуудал тулгарсан. Түүнчлэн зудын гамшигт хамгийн ихээр өртсөн сумдад шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн, сургуулийн барилга байгууламж эвдрэн, сургуулиуд хаагдсан зэрэг олон бэрхшээл тохиолдсон байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн зудын давтамж нэмэгдэх болсон нь хүн зоны амьжиргаа, байгаль орчны экосистемд олон талын сөрөг нөлөө үзүүлж байна. Зудын уршгаар малын тоо толгой их хэмжээгээр хорогдсоны зэрэгцээ ядарч туйлдсан мал сүргийн ашиг шим ихээхэн буурч, мах, сүү, ноос ноолуурын үйлдвэрлэлд нөлөөлж, улмаар малчдын орлого буурахад хүрсэн. Ийнхүү малчдад тулгарах эдийн засгийн дарамт нь айл өрхүүдийг ядууралд оруулж болзошгүй.

Зудын аюулд нэрвэгдсэн малчид хот суурин бараадан нүүж, хот суурингийн ядуурлын түвшинг нэмэгдүүлж, дэд бүтэц, байгаль орчинд нь хүнд дарамт учруулах эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлж байна.

Зудын аюул нь зөвхөн мал сүрэг төдийгүй ан амьтан, биологийн олон янз байдалд гүн гүнзгий нөлөөлж, байгаль орчин, экологийн нарийн төвөгтэй, уршигт үр дагавар авчирдаг. Мал сүргийн тоо толгой буурсаны адилаар олон мянган тоо толгой зэрлэг ан амьтдын идэш тэжээл хомсдож хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Зудын улмаас экосистемийн нарийн тэнцвэрт байдал алдагдаж, хэдийнээ эмзэг нөхцөлд байгаа зэрлэг ан амьтдын нөхөн сэргэлтэд урт хугацаа шаардагдах болжээ.

Зуд нь бэлчээрийн даац, газрын доройтолд нөлөөлж, улмаар урт хугацааны цөлжилтөд хүргэнэ. Бэлчээрийн даац хэтэрснээр газрын ургамалжилт муудаж, элэгдэлд илүү өртөмтгий болдог. Газрын ургамалан бүрхүүл муудсанаар цөлжих үйл явц хурдасч, газрын нөхөн сэргэх чадварт ноцтой нөлөөлнө. Бэлчээрийн даац хэтрэх, зудаас үүдэлтэй газрын эвдрэл хохирлын мөчлөг нь газрын чанарыг бүрмөсөн доройтуулж, экосистем болон хүн зоны амьжиргааг нөхөн сэргээхэд илүүтэй хүндрэл учруулж болзошгүй. Мал сүрэг олон тоогоор хорогдох нь тэдгээрийн сэг зэмийг зайлуулах, устгах нэмэлт сорилт бий болгодог. Түүнчлэн зудын үед хорогдсон олон мянган тоо толгой малын сэг зэм задралд орж хөрс, ус бохирдох эрсдэлтэй. Хорогдсон мал амьтдын сэг зэмийг хяналтгүйгээр зүй бусаар зайлуулах, устгаснаар усны нөөцөөс хамааралтай зэрлэг ан амьтад болон хүн зоны аль алинд нь сөргөөр нөлөөлж, халдварт өвчин дамжих эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй.

Эдгээр сорилтыг шийдвэрлэхийн тулд Монгол Улсын хүн, амьтан, ургамал, байгаль орчинд нөлөөлж буй эрүүл мэндийн харилцан уялдаа бүхий эрсдэлийг арилгах зорилгоор 2024 оны есдүгээр сард “Эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж эхэлсэн Ази Номхон далайн бүс нутгийн хоёр дахь улс болсон. Мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадварыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2024 оны дөрөвдүгээр сард Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг боловсруулж батлуулсан. Энэхүү хууль тогтоомжийг дэмжих үүднээс “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зайлуулах, устгах ажлыг зохистой удирдах, зоонозын өвчлөл, хүрээлэн буй орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2024 оны дөрөвдүгээр сард “Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 173 дугаар тогтоолыг батлан хэрэгжүүлж байна.

Биологийн олон янз байдлын алдагдал, газрын доройтол, усны бохирдол зэрэг нь экосистемийг нөхөн сэргээх урт хугацааны томоохон сорилтуудыг бий болгож байна. Монгол оронд тохиож буй зудын давтамж, ноцтой байдал нь газар зохион байгуулалтын тогтвортой менежмент, арга барилыг хэрэгжүүлэх, түүнчлэн цаашид тохиож болзошгүй гамшгийн нөлөөллийг сөрөн тэсвэрлэх чадавх, бэлэн байдлыг сайжруулах зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Улс төрийн нөхцөл байдал, засаглал

Монгол Улсын Их хурлын (УИХ) 2024 оны ээлжит сонгуульд Монгол ардын нам (МАН) нийт 68 суудал авч, 54 хувийн саналаар олонх болсон. Баруун төвийн үзэл баримтлалтай сөрөг хүчин болох Ардчилсан нам (АН) 42 суудал авч, УИХ дахь суудлаа 20-с 33 хувь болгож нэмэгдүүлсэн. Түүнчлэн ХҮН нам 8 суудал авч, УИХ дахь оролцоогоо 1.3-с 6 хувь болгож нэмэгдүүлсэн байна. Монголын ногоон нам, МҮАН-ын нэгдэл болох Үндэсний эвсэл, Иргэний зориг-Ногоон нам тус бүр дөрвөн суудал авсан. Ийнхүү хэд хэдэн намын төлөөлөл УИХ-д суудал авснаар залуу ардчиллын нөхцөлд иргэдийн төлөөллийг илүү олон талт болгох хүсэл эрмэлзлэл харагдаж байна. Үүний зэрэгцээ шинээр бүрдсэн УИХ нь түүхэндээ анх удаа хүн амын бүлгүүдийн олон төлөөллийг бүрдүүлсэн бөгөөд тэдгээрийн 60 хувь нь анх удаа сонгогдсон гишүүд байна. Казах үндэстний төлөөллийн тоо тав болж нэмэгдэв. Гадаад улсад амьдарч байгаа иргэдийн сонгуулийн оролцоо мөн нэмэгдсэн байна. Тус улсад УИХ-ын сонгууль амжилттай болж, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа чөлөөтэй явуулах боломжтой байсан хэдий ч өрсөлдөөний тэгш нөхцөл бүрдээгүй, сонгуулийн өмнөхөн цалин, нийгмийн халамжийн тэтгэмж нэмэгдсэн зэрэг нь эрх баригч намд шударга бус давуу байдал үүсгэж, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байсныг олон улсын ажиглагчид тэмдэглэжээ.

МАН УИХ-д олонхийн суудал авсан хэдий ч хамтарсан Засгийн газар байгуулсан. Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудлыг үр дүнтэй, шуурхай шийдвэрлэх, олон улсын харилцаа, геополитикийн эгзэгтэй нөхцөл байдлыг харгалзан үндэсний эв нэгдлийг эрхэмлэхийг гол зорилгоо болгон хамтарсан Засгийн газар байгуулах шийдвэрийг гаргасан байна. Ерөнхий сайд, 22 сайд, 16 яамтай хамтарсан Засгийн газар байгуулахаар МАН, АН, ХҮН намууд хамтын ажиллагааны санамж бичигт 2024 оны долдугаар сард гарын үсэг зурсан. Улс орны хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч буй сорилтуудыг хамтран шийдвэрлэхийн төлөө улс төрийн гурван намын дарга нар тууштай ажиллахаа баталж 2024 оны наймдугаар сард “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” эвслийн гэрээг байгуулсан. Уг гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан.

Үйл ажиллагааны хөтөлбөрт бүс нутгийн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхэд суурилсан засаглалын бодлого гэсэн бодлогын үндсэн дөрвөн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 619 арга хэмжээ тусгагдсан байна.

Нийслэл хот, аймаг, дүүрэг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-ын ээлжит сонгууль 2024 оны 10 дугаар сард болж өндөрлөсөн. МАН Улаанбаатар хотын ИТХ-д 40 суудал (нийт 45 суудалтай) авч, 14 аймагт ялалт байгуулж, Сүхбаатар дүүргээс бусад найман дүүрэгт ялалт байгуулав. АН долоон аймаг, нийслэлийн нэг дүүрэг, 150 сумын нутгийн өөрөө удирдах байгууллагад олонх болсон бол ХҮН нам орон нутгийн сонгуульд нэг ч суудал авч чадаагүй байна. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн санал хураалтад “ирцийн босго” тогтоогоогүй учир төрийн холбогдох байгууллагууд иргэдийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэхэд төдийлэн анхаарал хандуулаагүй байх магадлалтай.

Монголын хэвлэл мэдээллийн салбар олон төрөл хэлбэртэй боловч улс төрийн хувьд түйлширсэн байна. Хувийн болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн бүтцээс хараат бус байж чадахгүй байгаа нь ажиглагдаж байна. Монгол Улсад мэдээллийн эрх чөлөө, олон ургалч үзлийн зарчмыг хүндэтгэдэг хэдий ч эх сурвалжаа нууцлах эрх зүйн суурь хамгаалалт үгүй хэвээр байгаагийн зэрэгцээ гүтгэлгийн эсрэг хууль тогтоомж сул байгаа нь сэтгүүлчдийн эсрэг дур зоргоор шүүхэд нэхэмжлэл гаргах, улмаар хэвлэлд цензур тогтоход түлхэц болж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүднээс Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг (1998) илүү боловсронгуй болгох шаардлагатай байна. Хил хязгааргүй сэтгүүлчид (XXC/RSF) байгууллагаас жил бүр нийтэлдэг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексийн 2024 оны үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн 180 орноос 109-д эрэмблэгдэж, 2020 онтой харьцуулахад 36 байраар ухарчээ.

Монгол Улсын хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа 2000-аад оны эхэн үеэс улам бүр нэмэгдэж, хөгжлийн саад тээг болж байна. Монгол Улс хот, хөдөөгийн хөгжлийн цогц тогтолцоог бүрдүүлэхийн тулд хэд хэдэн стратегийн бодлого, хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байна. “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг стратегийн бодлого, эрх зүйн баримт бичиг нь бүс нутгийн өрсөлдөх чадвар сул, төрийн үйлчилгээ хангалтгүй, бодлогын тогтворгүй байдал зэрэг тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна. Монгол Улс 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан. 2024 оны Монголын эдийн засгийн чуулга уулзалтын гол сэдэв нь бүсчилсэн хөгжлийн асуудал байлаа. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол Улсыг баруун, хангайн, хойд, төвийн, говийн, зүүн, Улаанбаатарын гэсэн долоон эдийн засгийн бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлэхээр тодорхойлсон.

Бүс нутгийн төлөөлөл, засаглалыг сайжруулах зорилгоор УИХ-ын 2024 оны сонгуулийг бүсчилсэн тойргоор зохион байгуулсан. “Шинэ хоршоо-чинээлэг малчин” санаачилга нь уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилго бүхий Шинэ сэргэлтийн бодлогын Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын нэг хэсэг юм. 2024 онд “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд 60 сарын хугацаатай, 50 сая хүртэлх төгрөгийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийг зургаан хувийн хүүтэй олгохоор шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг Дэд бүтцийг хөгжүүлэх жил болгон зарласан. Засгийн газраас Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл, Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулахаар УИХ-д 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр өргөн барьсан. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний нэг үндсэн зорилт нь дагуул хотуудыг хөгжүүлэхэд чиглэж байна.

Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ), хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим

2024 оны есдүгээр сарын 22-нд болсон Ирээдүйн асуудлаарх дээд түвшний чуулга уулзалт (ИАДТЧ/SOTF)-аар улс орнуудын төрийн тэргүүн, удирдагчид хамтран зөвшилцөж Ирээдүйн төлөө гэрээ (ИТГ/GDC), Дэлхий нийтийн цахим хөгжлийн гэрээ (ДНЦХГ/GDC) болон Ирээдүй хойч үеийн асуудлаарх тунхаглал зэргийг баталсан билээ. Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага нь Монгол Улсын Засгийн газартай хамтран Ирээдүйн төлөө гэрээ (ИТГ/GDC)-г хэрэгжүүлэх талаар цуврал яриа хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн талаар тодорхой зөвлөмж боловсруулсан. ТХЗ-уудын хэрэгжилтийг хурдасгах талаар зөвшилцсөн эдгээр хэлэлцүүлгийн явцад дараах зөвлөмжүүд гарсан. Тухайлбал, 1) хувийн хэвшлийн өсөлт хөгжлийг нэмэгдүүлэхийн тулд зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, ногоон хөгжлийн гол салбаруудад олон талт хамтын ажиллагааг дэмжих, 2) бүх салбарыг чадавхжуулах, ТХЗ-ын талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн бодлогыг ТХЗ-ын зорилтуудтай уялдуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хамтын ажиллагааны механизмыг сайжруулах зэрэг зөвлөмжүүд гарсан байна.

Жендэрийн ялгаатай байдал нь ялангуяа эрэгтэйчүүдэд илүү сөргөөр нөлөөлж байна. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдтэй харьцуулахад дунджаар 9.4 жилээр богино байна. Хөдөө нутгийн эрчүүд, хөвгүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүд, охидтой харьцуулахад доогуур байгаа, мөн эмэгтэйчүүд эрчүүдээс илүүтэйгээр дээд боловсрол эзэмшиж байна.

Ялангуяа хөдөө орон нутагт ийм зөрүү илүү тод ажиглагдаж байна. Олон нийтийн дунд бэлгийн цөөнхийг гутаан доромжлох, гадуурхах үзэгдэл гарсаар байна. Сүүлийн үеийн судалгаагаар жендэрийн болон бэлгийн цөөнхийн санал асуулгад оролцогчдын 80 хувь нь ажил олгогчдод бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаа задруулахаас болгоомжилдог, 70 хувь нь гэр бүлийнхэндээ мэдэгдэхээс татгалздаг тухайгаа мэдээлжээ. 2023 оны Нийгмийн Үзүүлэлтийн Түүвэр Судалгаа (HYTC/SSIS)-ны урьдчилсан дүнгээс харахад Монгол Улсын хүн амын тодорхой бүлгүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн ялгаа оршсоор байгааг харуулж байна. Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд, охид нь эхчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, гэр бүл төлөвлөлт, аюулгүй үр хөндөлтийн үйлчилгээнд хамрагдахад саад бэрхшээл тулгарч байна.

Монгол Улсын залуучуудын (15-34 насны) дунд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж тэдэнд тулгарч буй сорилт, боломжуудыг тодорхойлох судалгааг 2024 онд хийв. Энэ судалгаагаар илэрсэн сорилтуудад цахим хөгжлийн ялгаа, сэтгэцийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, үр чадварын зөрүү, улс төрийн болон иргэний оролцоо, бүс нутгийн ялгаатай байдал зэрэг багтаж байна. Эдгээр сорилтыг шийдвэрлэх бодлогын дараах зөвлөмжийг боловсруулаа. Үүнд: 1) цахим дэд бүтцийг өргөжүүлж, цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг хөгжүүлэх замаар цахим бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, дэд бүтцийг сайжруулах, 2) шаардагдах санхүүжилт, нөөцийг нэмэгдүүлэх замаар залуучуудад ээлтэй сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх, 3) боловсролын байгууллага болон үйлдвэрлэлийн салбар хоорондын түншлэлийг хөхиүлэн дэмжих замаар зах зээлд шаардагдах үр чадварыг залуучуудад олгож, тэдний үр чадварын зөрүүг арилгах, 4) залуучуудад зориулсан платформыг хөгжүүлэх замаар тэдний улс төрийн бөгөөд нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих, 5) зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар бүс нутгийн ялгаатай байдлыг арилгах зэрэг болно.

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд улс төрийн сонгуульд санал өгөх, оролцох хувь харьцангуй өндөр байна. УИХ-ын 2020 оны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 85.7 хувь нь оролцож санал өгчээ. 2024 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлсэн Улс төрийн намуудын тухай хуульд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг улс төрийн сонгуульд нэр дэвшүүлсэн улс төрийн намуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх заалт тусгагдсан. 2024 оны сонгуулиар анх удаа намын жагсаалтаар хөгжлийн бэрхшээлтэй хоёр иргэн УИХ-ын гишүүнээр сонгогдсон. 2023 онд Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөгжлийн бэрхшээлтэй төрийн захиргааны албан хаагчдад тавигдах албан шаардлагыг хөнгөрүүлсэн төдийгүй

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Засгийн газрын яам, агентлагийн захиргааны албан тушаалд ажиллах боломжийг нэмэгдүүлсэн. Гэсэн хэдий ч Монголын нийгмийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хамгийн тусгаарлагдсан нийгмийн бүлэг хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо нь ажил хөдөлмөр хийх, нийгмийн харилцаанд оролцох, бие даан амьдрахад хүндрэлтэй зэргээс ихээхэн шалтгаалж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орлогынхоо дийлэнх хувийг эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээнд зарцуулж, боловсрол, өөрийгөө хөгжүүлэхэд орлогынхоо багахан хувийг зарцуулж байна.

Монгол Улсын 210 мянга гаруй иргэн (нийт хүн амын 6.1 хувь) гадаад улсуудад амьдарч байгаа гэсэн тооцоо бий. 2020 оны Хүн амын тооллогын дүнг 2010 оны тооллоготой харьцуулахад гадаадад амьдарч буй Монгол Улсын иргэдийн нийт тоо 14.2 хувиар өссөн байна. Тэдний дийлэнх хувь нь Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Япон, Казахстан, Чех, Австрали, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) зэрэг оронд амьдарч байна. Гадаадад амьдарч буй монголчууд цагаачлалын статус, соёлын ялгаа, хүлээн авагч орондоо нийгэмших нарийн төвөгтэй байдал зэргээс шалтгаалан нийгэм, эдийн засгийн олон сорилт бэрхшээлтэй тулгарч байдаг. Монгол Улсын Засгийн газар нь 2050 он хүртэлх хөгжлийн урт хугацааны бодлогодоо гадаадад амьдарч байгаа монголчуудынхаа асуудлыг тусгасан хэдий ч улс орныхоо хөгжилд тэдний чадавхийг бүрэн дүүрэн ашиглах бодлогыг тодорхойлж, оновчтой бүтэц, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээний 2024 оны нэмэлт тодруулга, Хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүдээс үзэхэд Хамтын ажиллагааны хүрээний тэргүүлэх чиглэлүүд, хүлээгдэж буй үр дүнгийн түвшинд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна. Харин Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Засгийн газарт үр дүнтэй дэмжлэг үзүүлэх үүднээс явцын дунд НҮБ-ын Удирдлагын Багийн зүгээс Хамтарсан ажлын төлөвлөгөөний (JWPs) холбогдох дэд үр дүнгүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэх, эсхүл шинэ хамтарсан хөтөлбөр боловсруулах шаардлага гарч болзошгүй байна.

Эдийн засгийн үзүүлэлтүүд

ДНБ-ий өсөлт (2024)

4.9%

7.4% (2023)

Худалдааны тэнцэл (2024)

4.170 тэрбум ам.доллар

5.937 тэрбум ам.доллар (2023)

Нийт гадаад өр (2024)

37.117 тэрбум ам.доллар

34.569 тэрбум ам.доллар (2023)

Засгийн газрын төсвийн тэнцэл (2024)

-776 тэрбум төгрөг

785.9 тэрбум төгрөг (2023)

Гадаад төлбөрийн урсгал тэнцэл (2024)

-2.373 тэрбум ам.доллар

121 сая ам.доллар (2023)

Инфляц (2024)
*Тухайн жилийн 12-р сар

9%

7.9% (2023)

Гадаад валютын нөөц (2024)
*Тухайн жилийн 12-р сар

5.5 тэрбум ам.доллар

4.9 тэрбум ам.доллар (2023)

Валютын албан ёсны ханш (сарын дундаж) (2024)

3,417.93

3,421.21 (2023)

Нийт малын тоо (2024)

57,647,940

64,681,880 (2023)

Дэлхийн инновацийн индекс (2024)
*133 улсаас

67 дахь байр

68 дахь байр (2023)

Дэлхийн өрсөлдөх чадвар (2024)
*67 улсаас

61 дэх байр

62 дахь байр (2023)

Нийгмийн үзүүлэлтүүд

Хөдөлмөрийн оролцооны түвшин (2024)

62.2%

60.5% (2023)

Ажилгүйдлийн түвшин (2024)
*4-р улирал

5.3%

3.9% (2023)

Эхийн эндэгдэл (2024)
*Хүний тоо

13

17 (2023)

Нялхсын эндэгдлийн түвшин (2024)
*1000 амьд төрөлтөд ногдох

12

12 (2023)

Бүртгэгдсэн гэмт хэрэг (2024)
*кейс

44,673

35,574 (2023)

Ядуурлын түвшин (2022)

27.1%

Хүн амын тоо (2024)

3,544,835

3,504,741 (2023)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо (2023)

111,228

Гадаадад амьдарч буй Монголчууд (2024)

210,000

(хүн амын 6.1%)

Хүний хөгжлийн индекс (HDI) (2022)

193 улсаас
96 дахь байр

Жендэрийн тэгш бус байдлын индекс (2022)

193 улсаас
72 дахь байр

Байгаль орчны үзүүлэлтүүд



Агаарын чанар

160
дахь байр



Хог хаягдлын менежмент

176
дахь байр



Ариун цэврийн байгууламж, ундны ус

75
дахь байр



Хүнд металлууд

103
дахь байр



Байгаль орчны гүйцэтгэлийн индекс (EPI) 2024 онд

143 дахь байр

(180 улсаас)



Хөдөө аж ахуй

174
дэх байр



Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

177
дахь байр



Биологийн олон янз байдал ба амьдрах орчин

34
дэх байр



Усны нөөц

74
дэх байр



Зудын нөлөөлөл 2023-2024 он

Малын хорогдол

8.1 сая толгой мал

Эдийн засаг 2024 оны долдугаар сарын байдлаар хөдөө аж ахуйн салбарын ДНБ 27 хувиар буурсан

Өрхийн орлого

Ойролцоогоор 12% буурсан (өрхийн гишүүн тутмын сарын цэвэр орлого)

Гол нэрийн мах, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах

Өрхийн 20 орчим хувь нь эрүүл мэндийн асуудалтай тулгарах

Нөлөөлөлд ихээр өртсөн сумдад шилжилт хөдөлгөөний түвшин өндөр болох

Сургуулийн үйл ажиллагаанд саад учрах, сургууль хаагдах

Засаглалын үзүүлэлтүүд

Парламент



Засгийн газрын бүрэлдэхүүн:

- Ерөнхий сайд
- 3 Шадар сайд
- 19 сайд



Хөгжлийн талаарх бодлогын баримт бичгүүд (2024)

- Алсын хараа 2050
- Шинэ сэргэлтийн бодлого
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028 он

- Монгол Ардын Нам (МАН): 68 (54%)
- Ардчилсан нам (АН): 42 (33.3%)
- ХҮН нам: 8 (6.3%)
- Үндэсний эвсэл: 4 (3.2%)
- Иргэний зориг-Ногоон нам: 4 (3.2%)

Хүйс:

- Эрэгтэй 94 (74.6%),
- Эмэгтэй 32 (25.4%)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс:

2 (1.6%)



Нутгийн удирдлагын байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл:

27.5%

(нийт 8031 суудлын 2212 суудал).



Цахим засаглалын хөгжлийн индекс (2024)
*193 улсаас

46 дахь байр

74 дэх байр (2023)



Авлигын төсөөллийн индекс (2024)
*180 улсаас

114 дэх байр

121 дэх байр (2023)



Хууль дээдлэх ёсны индекс (2024)
*142 улсаас

66 дахь байр

64 дэх байр (2023)



Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс (2024)
*180 улсаас

109 дэх байр

88 дахь байр (2023)

НҮБ-ын байр, Нэгдсэн Үндэстний гудамж-14,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14201,
Монгол Улс

Утас: (976-11) 327585



/unmongolia



@unmongolia

Вебсайт: mongolia.un.org